



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/09/СТА-ТТЗ





Аудитын код: САГ-2018/09/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn


Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Аудитор Б.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaab@audit.gov.mn

Улаанбаатар хот





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
С.БААТАРЖАВ ТАНАА

2018.03.23 № 01/797
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	4
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7.	Шилэн дансны мэдээлэл	4
2.8.	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9.	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1.	Авлагын талаар :	4
2.9.2.	Нууц хамгаалах ажилтанд олгох цалингийн нэмэгдлийн талаар:.....	4
2.9.3.	Нормативт хоол хүнсний зардлын талаар:	5
2.9.4	Төсвийн зарцуулалтын талаар:	5
2.9.5	Бараа бэлтгэн нийлүүлэх гэрээний үүргийн биелэлтийн талаар:.....	5
2.9.6	Цалин болон ХХОАТ-ын талаар:.....	6
2.9.7	Бүртгэл тайлагналын талаар:.....	6
2.9.8	Зардлын талаар:	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
2.16	Аудитын үр өгөөжийн талаар.....	8
3	Менежментийн захидал	9
3.1	Авлагын талаар.....	10
3.2	Нууц хамгаалах ажилтанд олгох цалингийн нэмэгдлийн талаар.....	11
3.3	Нормативт хоол хүнсний зардлын талаар.....	12
3.4	Төсвийн зарцуулалтын талаар.....	13
3.5	Бараа бэлтгэн нийлүүлэх гэрээний үүргийн биелэлтийн талаар.....	14
3.6	Үйл ажиллагааны талаар	15
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	16
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	16
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	17

4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.5	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
С.БААТАРЖАВ ТАНАА

2018.03.23 № 01/797

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Цагдаагийн ерөнхий газрын дарга, Цагдаагийн хурандаа С.Баатаржав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд Цагдаагийн ерөнхий газрын хэмжээнд урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн, мөн Санхүү хангамж, хангалт үйлчилгээний төвийн үйл ажиллагааны хэлбэрийг тодорхой болгох, өмнөх жилүүдэд баригдаж ашиглалтад орсон барилгуудын захиалагчийн хяналтын зардлын үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх, нормативт хоол хүнсний зардлаас ахмад настнуудад хүнсний хангалт олгосон, “нууц хамгаалах ажилтанд олгох цалингийн нэмэгдэл”-ийг олгох албан тушаалтныг тодорхой болгох, Бараа бэлтгэн нийлүүлэх гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитад Цагдаагийн ерөнхий газрын харьяа төсвийн 62, Төрийн өмчит үйлдвэрийн газар 2, нийт 63 байгууллага хамрагдсанаас 44 байгууллагад санал дүгнэлт гаргаж, 16 байгууллага түүвэрт хамрагдаж, 3 байгууллагад итгэл үзүүлсэн байна. Аудитаар 43 байгууллагад “зөрчилгүй” санал дүгнэлт, ТӨҮГ 1 байгууллагад “хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна. 1 байгууллага нууцын зэрэглэлтэй тул аудит хийгдээгүй болно.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 6-наас 2018 оны 3 дугаар сарын 19-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 24-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор О.Баярмаа, аудитор Б.Баярмаа нар хариуцан хэрэгжүүлэв.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 01/178 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Цагдаагийн ерөнхий газар нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам" зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант онд Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Мөн Дотоодын цэргийн тухай хууль 2017 оны оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 280 дугаар тогтоолоор Дотоодын цэргийн 05, 805 дугаар ангиуд шинээр байгуулагдсан байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 73 дугаар зүйлийн 73.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/262 дугаар тушаалыг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн А/220 дугаар тушаалаар Цагдаагийн төв байгууллага, зарим харьяа нэгжийн албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл зэргийг баталсан байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Тус байгууллага нь 2017 онд дараах зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх,
- Үндсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх,
- Цагдаагийн байгууллага, албан хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх,
- Албан хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах зорилт дэвшүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 10 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Цагдаагийн ерөнхий газар нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "aculous" програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед "бага" гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналт "хангалттай" байна гэж үзлээ.

2017 онд Цагдаагийн ерөнхий газар нь 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нийт 3,819.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар системийн хэмжээнд төлөвлөгөө гаргаж батлуулан тодорхой ажлуудыг зохион байгуулсны үр дүнд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоогдсон төлбөрийн актыг 100.0 хувь, албан шаардлагыг 95.2 хувь, зөвлөмжийг 92.8 хувьтай тус тус биелүүлсэн ба гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2017 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 6/807, мөн оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 6/1038 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

2017 онд цагдаагийн байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх чиглэлээр зөвлөмж, аргачлал гаргаж салбар байгууллагууддаа хүргүүлэн, үр дүнг нь тооцож ажилласан байна. Тухайлбал:

- Төсвийн зарлагыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах,
- Цагдаагийн байгууллагын 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргахад анхаарах,
- Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааг дүгнэсэн үнэлгээг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг сайжруулах,
- Үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа эд хөрөнгийн дансны ангилал болон нэршил зөрүүтэй хөрөнгийн залруулга хийж, бүртгэх,
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой,
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглахаар шинээр бий болгосон мэдүүлэг авах тусгай өрөөг засварлах, гарсан ажил гүйлгээг бүртгэх,
- Цагдаагийн байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахад анхаарах зэрэг 8 зөвлөмж,
- Цагдаагийн байгууллагын хэмжээнд үндсэн хөрөнгө, бараа материал, үнэт цаас, мөнгөн хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх, тооцоо бодох,
- Үнэт цаасны бүртгэл хөтлөх,
- Шатахуун, тослох материалын бүртгэл хөтлөх,
- Албан хаагчдын хэрэглэж байгаа үндсэн хөрөнгө, бараа материалыг нярваас эд хариуцагч бүрээр картлах, тооллогын дүнг нягтлан бодох бүртгэлийн програмд бүртгэх зэрэг 4 аргачлалыг тус тус боловсруулан холбогдох хүснэгт, тооцооллын хамт цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлэн, биелэлтийг тооцож, байгууллагын санхүү бүртгэлийн ажил болон төсвийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд голлон анхаарч ажилласан нь шилдэг туршлага байлаа.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Цагдаагийн ерөнхий газар нь 12 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 167,578.8 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 165,903.1 сая төгрөг буюу 99.0 хувьтай байна. Тайлант онд батлагдсан төсөвт зардлыг 1.0 хувиар буюу 1,675.6 сая төгрөгөөр хэмнэжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 92.7 сая төгрөг буюу 11.9 хувиар давж биелсэн байна.

Батлагдсан төсөвт зардлыг зардлын зүйл анги бүрээр хэмнэж ажилласан байна.

2.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газар нь шилэн дансанд байршуулах мэдээллээ Шилэн данс нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.shilendans.gov.mn>, байгууллагын цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбараар бүх мэдээллээ хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

2017 онд өөрийн байгууллагын цахим хуудас болон нэгдсэн цахим хуудасны "Төсөв/гүйцэтгэл", "Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт", "Бусад" зэрэг бүх мэдээллүүдийг байршуулан, улирлын тайлангаа ТЕЗ-ын дотоод аудитын албанд сар бүр илгээж хэвшсэн, УАГ-аас 2017 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн Нийцлийн аудитад хамрагдаж, хангалттай үнэлгээ авсан байна.

2.8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын эрсдэлийг 5 чиглэлээр тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

2.9. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1. Авлагын талаар :

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн алба нь Сангийн яамны нэгдсэн дансанд төвлөрүүлсэн барилга захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл 42.5 сая төгрөгийг буцааж авахаар авлага үүсгэж, авлага нэмэгдүүлсэн байна. Гэвч уг захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл нь өмнөх жилүүдэд баригдаж ашиглалтанд орсон барилгуудын хяналтын зардлын үлдэгдэл бөгөөд тус байгууллагад зарцуулагдахгүйгээр улсын төсөвт төвлөрүүлэх үлдэгдэл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага дансанд бүртгэгдсэн захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл 42.5 сая төгрөгийг 2018 онд Сангийн яаманд буцаан төвлөрүүлэх зөвлөмж өгөх.

2.9.2. Нууц хамгаалах ажилтанд олгох цалингийн нэмэгдлийн талаар:

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн Б/527 дугаар тушаалаар Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны жагсаалт, түүнд цалингийн нэмэгдэл олгох хувь хэмжээг баталж, нууц хамгаалах ажилтны нэмэгдлийг албан хаагчдад олгох шийдвэр гаргаж 11, 12 дугаар сард 155 албан хаагчдад нийт 37.8 сая төгрөгийн нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдлийг олгосон байна. Дээрх нууцын нэмэгдлийг олгосон 102 албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод нууц хамгаалах талаар тусгагдаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 4.1-д "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид холбогдох дээд шатны байгууллагад хандан өөрийн байгууллагын онцлогт тохируулан нууц хамгаалах ажилтан, нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгох, холбогдох журмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

2.9.3. Нормативт хоол хүнсний зардлын талаар:

Тайлант онд нормативт хоол хүнсний зардлаас байгууллагын ахмад настнуудад 30.8 сая төгрөгийн хүнсний хангалт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нормативт хоол хүнс нь хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаас батлагдсан норм, нормативын дагуу төлөвлөгдөж, гүйцэтгэл нь тооцогддог бөгөөд төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хоолны зардлын нийт хэмжээ нь тухайн үйлчилгээг авсан нийт хүний тоотой шууд уялдсан байх, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, мөн алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

2.9.4 Төсвийн зарцуулалтын талаар:

ЦЕГ-ын хэмжээнд тайлант онд урсгал зардлаас нийт 232.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж харьяа байгууллагуудад хуваарилсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх зөвлөмж өгөх.

2.9.5 Бараа бэлтгэн нийлүүлэх гэрээний үүргийн биелэлтийн талаар:

1. Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-тай 2017 оны 5 сарын 31-ний өдөр байгуулсан 01/2017-УЗ-26 дугаартай, 346.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хувцас оёж нийлүүлэх гэрээ", мөн 2017 оны 6 сарын 28-ны өдрийн 01/2017-УЗ-55 дугаартай, 136.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Бараа бэлтгэн нийлүүлэх" гэрээний үүргийн биелэлтийг тооцож тус тус дүгнээгүй, 125.4 сая төгрөгийг урьдчилж гарсан зардалд бүртгэж тайлагнасан,

2. Цагдаагийн ерөнхий газрын "Өүлэн Менч" ХХК-тай 2017 оны 6 сарын 26-ны өдөр байгуулсан 01/2017-УЗ-45 дугаартай, 169.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Бараа бэлтгэн нийлүүлэх" гэрээний үүргийн биелэлтийг тооцож дүгнээгүй, 84.5 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай гэрээнд заасан хугацаанд бараа, ажил үйлчилгээг хүлээж авч, гэрээний үүргийн биелэлт, үр дүнг тооцож ажиллах зөвлөмж өгөх.

2.9.6 Цалин болон ХХОАТ-ын талаар:

Орон нутгийн болон Нийслэлийн цагдаагийн газар түүний харьяа байгууллагууд:

- Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтэс, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Ховд аймаг дахь цагдаагийн газар нь зарим ажилтаны цалингаас хувь хүний орлогын албан татвар дутуу суутгасан, хувь хүмүүсээс суутгасан ХХОАТ-ыг төсөвт төвлөрүүлээгүй, хувь хүмүүсээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээний хөлснөөс ХХОАТ суутгаж тооцоогүй зэрэг 2.2 сая төгрөгийн зөрчил,
- Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс, Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар нь даргын тушаалыг хэрэгжүүлээгүй цалингийн суутгалыг дутуу суутгасан, цалингийн урьдчилгааг суутгаагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, цалингаас суутгасан НДШ-ийг нийгмийн даатгалын тайланд тусгаагүй, ажлын өдөр буруу тооцож илүү цалин олгосон, сахилгын шийтгэл хүлээсэн, шийтгэлгүйд тооцох хугацаа нь болоогүй албан хаагчид 300.0 мян төгрөгийн урамшуулал олгосон зэрэг 4.2 сая төгрөгийн зөрчил,
- Орхон аймаг дахь цагдаагийн газар нь нэг ажилтанд листийг давхардуулан 2 удаа олгоод 0.9 сая төгрөгийг дутуу төлүүлсэн,
- Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс томилолтын зардлыг буруу тооцож нийт 0.3 сая төгрөгийн илүү олгосон,
- Ховд аймаг дахь цагдаагийн газар, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтэс зэрэг нь анхан шатны баримтгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэсэн 2.2 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.1, 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 22 дугаар зүйлийн 22.1.4, 23 дугаар зүйлийн 23.1-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЦЕГ-ын харьяа байгууллагуудад аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас зөрчлийг давтан гаргахгүй байх, 9.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 төлбөрийн акт тогтоогдсон.

2.9.7 Бүртгэл тайлагналын талаар:

Орон нутгийн болон Нийслэлийн цагдаагийн газар түүний харьяа байгууллагууд:

- Орхон аймаг дахь Цагдаагийн газар нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах талаар зөвлөмж өгсөн боловч тайлант онд 6.4 сая төгрөгийн авлага, 3.1 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, мөн 4-р улирлын суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайланг гаргаагүй,
- Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс нь урамшуулалт эргүүлийн цалин, томилолт, хоол, сургалтын төлбөрийн 24.5 сая төгрөгийг бэлнээр олгож кассын тайлан гаргаагүй, Бараа материалын тодруулга тайлангаас эд хариуцагчийн тайлангийн эцсийн үлдэгдэл 4.1 сая төгрөгөөр зөрүүтэй, бараа материалын 15.9 сая төгрөгийн орлого, зарлагын баримт үйлдээгүй, НДШ-ийг 0.2 сая төгрөгөөр илүү төлж авлагаар бүртгээгүй,
- Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс нь НДШ-ийн тайланд цалингийн зардлыг 20.7 сая төгрөгөөр илүү тайлагнаснаас 0.8 сая төгрөгийн шимтгэл илүү төлсөн, НДШ-ийн авлагын эхний, эцсийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан,

- Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс нь эргүүлийн автомашин засвартай хугацаанд 0.6 сая төгрөгийн шатахуун зарцуулснаар замын тооцооны хуудас бичсэн зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЦЕГ-ын харьяа байгууллагуудад аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 58.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага өгөгдсөн.

2.9.8 Зардлын талаар:

ЦЕГ-т тайлан нэгтгэгддэг Монгол тамга ТӨҮГ:

- Няравыг үүрэгт ажлаас нь үндэслэлгүй чөлөөлсны улмаас Шүүхийн шийдвэрээр 2.4 сая төгрөг, даргын тушаалаар шүүхийн шийдвэр гарснаас хойш ажилд авах хүртэлх 3 сарын цалин 2.4 сая төгрөг, нийт 4.8 сая төгрөгийг хохиролд олгосон,
- Монгол тамга ТӨҮГ-ын дарга нь зээл, урьдчилгаа нэрээр 11.6 сая төгрөгийн авлага үүсгэж 3.5 сая төгрөгийг цалингаас суутгуулах хэлбэрээр барагдуулж, үлдсэн 8.1 сая төгрөгийг төлж барагдуулаагүй, өмнө оны авлагын үлдэгдэл 122.5 сая төгрөг, нийт 130.6 сая төгрөгийн өртэй,
- Тайлант онд байгууллагаас Улуснэт, Юнивишн, Ёкозунанэт зэрэг 3 байгууллагад гэрээгүйгээр нийт 0.7 сая төгрөг интернетийн төлбөр төлсөн, мөн бэлтгэл хурандаа Цэрэнчимэдийн шагналын мялаалганд 0.5 сая төгрөг, Дэлгэрсайхан, Жаргалсайхан нарын хувийн газрын кадастрын зургийн төлбөрт 0.2 сая төгрөг, нийт 1.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Даргын тушаалаар Рэнцэнтавхайн хүүхдийн сургалтын төлбөрт 1.2 сая төгрөг, нягтлан бодогч Өнөбатын хүүхдийн сургалтын төлбөрт 1.9 сая төгрөг, нийт 4.5 сая төгрөгийг олгосон,
- Санхүүгийн тайланд тусгагдсан 55.7 сая төгрөгийн авлага, 97.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4-т заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2018 оны 9 дүгээр тогтоолоор "Монгол тамга ТӨҮГ"-ын татан буугдах шийдвэр гарсан тул дээрх 141.3 сая зөрчлийг арилгах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан шаардлага өгөгдсөн.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү хангамж, хангалт үйлчилгээний төв нь төсвийн шууд захирагчийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаггүй, төсөв захирагчгүй, агуулах хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг нэгж боловч өмнөх онуудад болон 2017 онд санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлангуудыг гаргаж, мөнгөн хөрөнгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргахгүй байгаа нь стандарт бус байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн

тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна” 8.1.1-д “санхүүгийн байдлын тайлан”, 8.1.2-т “орлогын дэлгэрэнгүй тайлан”, 8.1.3-т “өмчийн өөрчлөлтийн тайлан”, 8.1.4-т “мөнгөн гүйлгээний тайлан,” 8.1.5-д “санхүүгийн тайлангийн тодруулга” гэж заасныг зөрчиж байна.

Цаашид тус төвийн үйл ажиллагааг төсвийн шууд захирагчийн хэлбэрээр өөрчлөх, эсвэл шууд агуулахын зориулалтаар ажиллуулж, тайлан тэнцлийг нь Санхүү аж ахуйн алба гаргадаг байхаар зохицуулан бүтэц зохион байгуулалт хийж, холбогдох хууль эрх зүйн акт, стандартыг мөрдөж ажиллахад анхаарах,

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар *Юрон нутгийн болон нийслэлийн цагдаагийн газар түүний харьяа байгууллагууд, ТӨҮГ орсон* нийт 2,516.9 сая төгрөгийн 168 алдаа, зөрчил илэрсэн ба 1,857.6 сая төгрөгийн 56 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй 9.8 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт, 58.8 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 590.7 сая төгрөгийн алдааг залруулах 98 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 3,819.6 сая төгрөгийн 125 алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 38.0 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах төлбөрийн акт, 556.2 сая төгрөгийн 41 зөрчлийг арилгах албан шаардлага, 3.225,3 сая төгрөгийн алдааг залруулах 73 зөвлөмж өгөгдсөн байна. Өмнөх оны аудитаар тогтоогдсон төлбөрийн актыг 100 хувь, албан шаардлагыг 95.2 хувь, зөвлөмжийг 92.8 хувьтай тус тус биелүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 195,297.5 сая төгрөг бөгөөд 1 хувиар буюу 1,952.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2.16 АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТАЛААР

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар урьдчилсан байдлаар нийт 333.0 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэсэн болно.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Цагдаагийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Улсын төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлэх шаардлагатай өмнөх жилүүдийн захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл 42.4 сая төгрөгийг Сангийн яамнаас буцаан авахаар авлага үүсгэн бүртгэж, авлагыг бодит бусаар өсгөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6-д "Үлдэгдэл ашгийг төсвийн жилийн эцэст тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэснийг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулиудын холбогдох заалтууд зөрчигдөх, Санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд хангагдахгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

Байгууллагын жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл 42.4 сая төгрөгийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлэх,

Авлагын тооцоог үнэн зөв хийж, баталгаажуулан, авлагын дансанд бодит бус авлагыг бүртгэж, тайлагнахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.2 Нууц хамгаалах ажилтанд олгох цалингийн нэмэгдлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн Б/527 дугаар тушаалаар Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны жагсаалт, түүнд цалингийн нэмэгдэл олгох хувь хэмжээг баталж, нууц хамгаалах ажилтны нэмэгдлийг албан хаагчдад олгох шийдвэр гаргаж 11, 12 дугаар сард 155 албан хаагчдад нийт 37.8 сая төгрөгийн нэмэгдлийг олгосон байна. Дээрх нууцын нэмэгдлийг олгосон 102 албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод нууц хамгаалах талаар тусгагдаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 4.1-д "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид холбогдох дээд шатны байгууллагад хандан өөрийн байгууллагын онцлогт тохируулан нууц хамгаалах ажилтан, нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгох, холбогдох журмыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.3 НОРМАТИВТ ХООЛ ХҮНСНИЙ ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд Нормативт хоол хүнсний зардлаас байгууллагын ахмад настнуудад 30.8 сая төгрөгийн хүнсний хангалт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Нормативт хоол хүнс нь хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаас батлагдсан норм, нормативын дагуу төлөвлөгдөж, гүйцэтгэл нь тооцогддог бөгөөд төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хоолны зардлын нийт хэмжээ нь тухайн үйлчилгээг авсан нийт хүний тоотой шууд уялдсан байх, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.4 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

ЦЕГ-ын хэмжээнд тайлант онд урсгал зардлаас нийт 232.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж харьяа байгууллагуудад хуваарилсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, мөн алдааг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

**3.5 БАРАА БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН
БИЕЛЭЛТИЙН ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

1. Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-тай 2017 оны 5 сарын 31-ний өдөр байгуулсан 01/2017-УЗ-26 дугаартай, 346.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хувцас оёж нийлүүлэх гэрээ", мөн 2017 оны 6 сарын 28-ны өдрийн 01/2017-УЗ-55 дугаартай, 136.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Бараа бэлтгэн нийлүүлэх" гэрээний үүргийн биелэлтийг тооцож тус тус дүгнээгүй, **125.4 сая** төгрөгийг урьдчилж гарсан зардалд бүртгэж тайлагнасан,

2. Цагдаагийн ерөнхий газрын "Өүлэн Мөнч" ХХК-тай 2017 оны 6 сарын 26-ны өдөр байгуулсан 01/2017-УЗ-45 дугаартай, 169.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Бараа бэлтгэн нийлүүлэх" гэрээний үүргийн биелэлтийг тооцож дүгнээгүй, **84.5 сая** төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Авлага, өр төлбөр үүсэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,
Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай гэрээнд заасан хугацаанд бараа, ажил үйлчилгээг хүлээж авч, гэрээний үүргийн биелэлт, үр дүнг тооцож ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг **2018 оны 9 дүгээр сарын 1-ний** дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.6 Үйл ажиллагааны талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү хангамж, хангалт үйлчилгээний төвийн үйл ажиллагааны хэлбэр нь тодорхой бус байгаагаас шалтгаалан төсвийн захирагчгүй боловч өмнөх онуудад болон 2017 онд санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлангуудыг гаргаж, мөнгөн хөрөнгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргалгүйгээр ирсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна" 8.1.1-д "санхүүгийн байдлын тайлан", 8.1.2-т "орлогын дэлгэрэнгүй тайлан", 8.1.3-т "өмчийн өөрчлөлтийн тайлан", 8.1.4-т "мөнгөн гүйлгээний тайлан;" 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга" гэж заасныг зөрчиж байна

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актууд болон НББОУС, СТОУС- ууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Санхүү хангамж, хангалт үйлчилгээний төвийн үйл ажиллагааны хэлбэрийг тодорхой болгож, төсвийн шууд захирагчийн хэлбэрээр эсвэл агуулахын зориулалтаар ажиллуулах талаар холбогдох шийдвэрийг гаргуулан холбогдох хууль, стандартыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.